



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/681

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн Халиун сумын нэгдсэн халаалтын зуух, төвлөрсөн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
	З.Жаргалтуяа	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Лхагва-Очир	(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн хяналтын улсын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын улсын байцаагч)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
	Д.Баярчулуун	(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн ерөнхий инженер)
	Ж.Мянганбаяр	(Халиун сумын Засаг дарга)
	Ц.Нарангэрэл	(Халиун сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
	Б.Банзрагч	(“Тэргүүлэн” ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)

01001294

2.

Э.Батсайхан ("Онолт од" ХХК-ийн захирал)  
(зохиогч)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын инженерийн  
байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Халиун сумын Засаг дарга (Ж.Мянганбаяр)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ